

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН
ЗӨВЛӨМЖ**

2023.04.07

Дугаар 2023/04

Улаанбаатар хот

Дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 1 дүгээр улирлын тайланд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Нэг. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар

1.1 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд;

1.1.1 Тогтоолын 1.3.1 дэх заалтыг хэрэгжүүлэгч Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсүүд хэрэгжилтийг тайлагнахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, насанд хүрээгүй хүүхэд зэрэг онцгой халамж шаардлагатай иргэдрүү чиглэсэн орчны стандарт, тохижилтын талаар хийсэн ажлуудын үр дүн, тоо, чанарын стандартын үзүүлэлтийг тусгах;

1.1.2 Тогтоолын 1.3.3, 1.4.1 дэх заалтыг хэрэгжүүлэгч Цагдаагийн газар хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүнг нотлогдохуйц бодит тоон үзүүлэлттэй, тухайлбал нийслэл дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн камержуулалт, гэрэлтүүлэг зэрэг холбогдох бусад мэдээллийг бүрэн тусгах;

1.1.3 Тогтоолын 1.3.4 дэх заалтыг хэрэгжүүлэгч Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтсүүд нутаг дэвсгэрийн бүх сургууль, цэцэрлэгийн стандартын үнэлгээний талаарх мэдээлэл, түүний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг илтгэх нарийвчилсан судалгаа, тоон үзүүлэлт бүхий мэдээллийг тусгах;

1.2 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 165 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд;

1.2.1 Тогтоолын 1 дэх заалтыг хэрэгжүүлэгч Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтсүүд 2018 оны 6, 8, 10 дугаар сард Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд хийсэн дотоод, гадаад орчны аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын явцын дүнг үндэслэн хэрэгжүүлсэн арга хэмжээ болон эрсдэлийн үнэлгээг тогтмол хийлгэж байгаа эсэх талаар мэдээллийг бүрэн тусгах;

1.2.2 Тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлэгч Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс хүүхдийн хүчирхийлэл, гэмт хэрэг, ослын дуудлагаас үндэслэн шалтгаан нөхцөлийг тогтоосон нарийвчилсан судалгаа, тоо баримт, түүнд тулгуурлан хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг тоо баримттай тайлагнах;

1.3 Шийдвэрийн хэрэгжилтийг хангахад тулгарч буй бэрхшээл, удааширч буй шалтгаан нөхцөлийг нотлогдох баримттай дурдах;

1.4 Тухайн шийдвэр /хууль, тогтоомж, захиргааны акт/-ийн агуулгаас хамааран богино, дунд, урт хугацаанд хэрэгжиж буй тодорхой үр дүнд хүрсэн гол гол арга хэмжээний хэрэгжилтийн харьцуулсан тоо, чанарын үзүүлэлт, нотлогдохуйц мэдээллийг товч тодорхой бүрэн тайлагнах;

1.5 Нийт хэлтэс албад аливаа тайлан мэдээ, биелэлт нэгтгэн гаргаж буй албан хаагчдын ур чадварыг тогмол дээшлүүлж, тогтвор суурьшилтай ажиллахад онцгой анхаарууштай.

Хоёр. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн зөрчил болон гомдлыг бууруулах чиглэлээр

2.1 Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 06/382-388 дугаар албан бичгээр Хяналт шинжилгээ, үнэлгээний 2023/03 тоот зөвлөмж хүлээн авсан Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Боловсролын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Газар зохион байгуулалтын алба зэрэг байгууллагууд өмнө өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийг эргэж тайлагнах;

2.2 Засаг даргын Тамгын газар, зарим хороод, Цагдаагийн газар, Газар зохион байгуулалтын алба, Эрүүл мэндийн төв, Боловсролын хэлтэс, Нэгдсэн эмнэлэг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс зэрэг байгууллагууд гомдлын тоог бууруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээ авч ажиллах;

2.3 Нийт хэлтэс, албадын өргөдөл гомдол хариуцсан албан хаагчид гомдлыг агуулгаар нь ангилж, байгууллагын зүгээс бууруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

2.4 Цагдаагийн газар, Эрүүл мэндийн төв, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн төв болон бусад хэлтэс, албад байгууллагын үйл ажиллагаа болон нэр бүхий албан хаагчийн ёс зүй, ажлын хариуцлагын талаар гаргасан иргэдийн гомдлыг судлан цаашид дээрх 2 агуулгаар гомдол гаргахгүй байхад онцгой анхаарч, шуурхай арга хэмжээ авч, хэрэгжүүлэн тайлан мэдээг дүүргийн Засаг даргын Тамгын газарт тогмол тайлагнаж хэвших нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖТЭЙ ТАНИЛЦСАН



С.ЭНХБАЯР

Засаг даргын Тамгын газрын дарга

ЗӨВЛӨМЖ ХЯНАСАН:

Л.ОТГОНБАЯР

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч

ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН:

Н.АЛДАРМАА

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн